

«МОНГОЛОР» ХУВЬЦААТ НИЙГЭМЛЭГ, ТҮҮНИЙ
АЛТ ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д.Уламбаяр*

Товч утга

ХХ зууны эхээр Хаант Орос, Хятад, Өрнөд Европын компаниуд Монголд худалдааны үйл ажиллагаа эрхэлж байсан төдийгүй ашигт малтмал, тухайлан алт олборлох чиглэлээр өргөн хүрээтэй уурхайн үйл ажиллагаа явуулах болжээ. 1900 онд Санкт-Петербургт байгуулагдсан «Түшээт хан, Цэцэн хан аймгийн Уурхайн хэрэг эрхлэх газар» буюу товчоор «Монголор» алт олборлох хувьцаат нийгэмлэгийн дүрмийн сан анх 2,8 сая мексик долларын хөрөнгөтэй байсан нь 1919 он болоход 10 сая 471 мянган мексик долларын өртөгтэй, 606 пүү буюу 11 тн илүү алттай болсон байна. Үүнээс зээл, хүү, бусад бүх зардлаа хасаад 5 дахин илүү ашиг олж авчээ. «Монголор» нийгэмлэг 4 жилд нэг тонноос дээш, үүний дотор 1910 онд 1974,4кг алт олборлосон нь Монгол Улсын түүхэнд 1990 оны байдлаар олборлосон хамгийн их алт болж байна. Олборлосон алтны нилээд хэсэг нь Тяньжинээр Америкт, багагүй хэсэг нь Оросоор дамжин Берлин, Амстердам, Парист гарч байжээ. 1912 он гэхэд 1 сая 154 мянга 222 рублийн үнэ бүхий алт дээрх сувгаар гарчээ.

Богд гэгээний Засгийн газар байгуулагдсаны дараа 1912 оны 6 дугаар сарын 22-нд “Монголор”-той 22 зүйл бүхий гэрээ байгуулж, 1931 он хүртэл 19 жилийн хугацаатай концесс шинээр олгохдоо дурдсан хоёр аймгийг л хамруулжээ. Хөгжлөөр буурай байсан Монгол оронд олон улсын хүчирхэг капиталын хөрөнгө оруулсан алтны энэ нийгэмлэг онцгой эрхтэй байв. Тухайлбал, өөрийн цагдаа, шүүхтэй, утсан болон зам харилцаатай, гэрэл цахилгаантай, засварын газартай, тухайн үедээ орчин үеийн гэж хэлж болохуйц дэд бүтэцтэй, Америкт үйлдвэрлэсэн уурын болон усан тээрэмтэй, олон арван фордын машин техниктэй, хамгийн их нь 10 мянга гаруй ажилчидтай жижигхэн вант улс байжээ.

* Д.Уламбаяр – Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улс судлалын төвийн захирал доктор (Ph.D), профессор

«Монголор» нь Монголд төдийгүй Орос ч капиталист томоохон аж ахуйн нэгжид тооцогдож байв.

Түлхүүр үг: «Монголор»-“Mongolor”, Хамтарсан хувьцаат нийгэмлэг-Joint Stock company, Орос-Хятадын банк-Russian-Chinese bank, мексик доллар-mexican dollar, Хувьцаа-Share, Хувьцаа эзэмшигч-Shareholder, Концесс-Concession, Дүрмийн сан-Registered capital, Удирдах зөвлөл- Board of directors, Ногдол ашиг-Dividend

«Монголор»-ын үндэс суурь тавигдсан нь

XX зууны эхээр Хаант Орос, Америк, Өрнөд Европ, Хятадын компаниуд Монголд худалдааны үйл ажиллагаа эрхэлж байсан төдийгүй ашигт малтмал, тухайлан алт олборлох чиглэлээр өргөн хүрээтэй уурхайн үйл ажиллагаа явуулах болжээ. 1900 оноос Түшээт хан, Цэцэн хан аймгийн Ерөө, Хэрлэнгийн сав газруудад Орос, Франц, Хятад, Бельгийн хувь нийлүүлсэн алтны уурхай нээжээ. 1862 оны Тяньжиний конвенцийн дагуу Англи, Орос, Америк, Франц зэрэг улсын иргэд, хайгуул шинжилгээний ангийнхныг Монгол нутгаар аялахыг Манжийн Засаг захиргаа зөвшөөрчээ. 1898 онд Ли Хунжаны Европын хэрэг эрхлэсэн хувийн нарийн бичгийн дарга фон Гроть Чингийн засгийн зөвшөөрөл авч, Өргөө дэх манж амбан Лиен Шун [Lien Shun, Qing Commissioner at Urga], Улиастайн амбан сайд Лянь-тай [Lian Tai Qing Commissioner at Uliastai] лугаа хэлэлцээ хийж Түшээт хан, Цэцэн хан аймгуудын Хэрлэн, Ерөө, Туул, Орхон Сэлэнгэ мөрний сав нутагт 250 мянган га газарт [өмнө зүгт Өргөөгөөс хойд зүгт Транс-Сибирийн төмөр зам хүрэх Верхнеудинск болон Хиагт хүртэл] алт хайж, олборлолт явуулах 25 жилийн хугацаатай концессийн эрх авсан байна.

«Түшээт хан, Цэцэн хан аймгийн Уурхайн хэрэг эрхлэх газар» буюу товчоор «АО Монголор»-ын («ор» гэдэг нь францаар алт гэсэн үг ажээ Д.У) хуулийн ёсоор бүртгүүлсэн албан ёсны бүтэн нэр нь **«Акционерное Общество Руднаго дьла Тушетухановскаго и Цеценхановскаго аймаковъ въ Монголии»**, харин францаар **«Societe Anonyme Miniere des Aimaks de Touchetoukhan et de Tsetsenkhan en Mongolie»** хэмээх агаад сайхь нийгэмлэгийн дүрмийг 1900 оны 2 дугаар сарын 13-нд болсон хувь нийлүүлэгчдийн анхны хурлаар баталж, улмаар Сангийн сайд батламжилж, сарын дараа буюу 3 дугаар сарын 13-нд үйл ажиллагаагаа албан ёсоор эхэлжээ. Тус хувьцаат нийгэмлэгийн дүрмийн сан анх 2,8 сая

мексик долларын (1 мексик доллар=1,97 ам.\$) хөрөнгөтэй байсан нь 1919 он болоход 10 сая 471 мянган мексик долларын өртөгтэй, 606 пүү (пуд=оросын хүндийн жин хэмжүүрийн нэгж, 1 пуд=16.5 кг=36.113 фунт) буюу 11 тн илүү алттай болсон байна. Үүнээс зээл, хүү, бусад бүх зардлаа хасаад 5 дахин илүү ашиг олж авчээ.¹

«Монголор»-ын байгуулагдсан түүх ихээхэн сонирхолтой байдаг. 1896 онд Чин улсын төрийн томоохон зүтгэлтэн, 1895 оны Шимоносекийн гэрээнд гарын үсэг зурж байсан, эзэн хааны Бүрэн эрхт тусгай төлөөлөгч (Viceroy or Ambassador-at-large) Ли Хунжан Санкт Петербургт Хаант Оросын Сангийн сайд, дипломатч, гүн Сергей Юльевич Виттегийн (1849-1915) урилгаар айлчилжээ. Ли Хунжан II Николайг Оросын эзэн хааны ширээнд өргөмжлөх ёслолд оролцож, мөн Японы эсрэг цэргийн холбоотны нууц гэрээнд Гадаад хэргийн сайд А.Лобанов-Ростовский лугаа хамт гарын үсэг зурснаас гадна Дорнод Хятадын төмөр зам [ДХТЗ], Орос-Хятадын банк түүнчлэн Монголд алтны уурхай нээж ажиллуулах талаар нууц хэлэлцээг давхар хийх явдал байсан бөгөөд зорилгоо ч биелүүлжээ.

Ли Хунжан (*Li Hongzhang* 1823-1901) бол Зүүн Хойд Хятадын Хэбэй мужийн Аньфуд төрсөн манж үндэстэн бөгөөд Чин гүрний төрийн нэрт зүтгэлтэн, дипломатч, генерал цолтой, язгууртан гаралтай тэрбээр эзэн хааны *shengyuan* хэмээх шаталсан төрийн шалгалтад тэнцэж, Чингийн төрд алба хаших болжээ. Дараа нь 1847 онд эзэн хааны дээд түвшний *jinshi* зэрэг хамгаалж, хоёр жилийн дараа Ханлин академийг дүүргэсэн байна. Англи хэл бичигтэй хүн байсан байх бөгөөд Америкийн дипломатч, Тяньжин дэх дэд консул, анхны дөрвөн жилийн хөтөлбөртэй Тяньжиний Их сургуулийг үндэслэгч Чарльз Даниел Теннийг гэрийн багшаар хөлслөн англи хэл, өрнөдийн шинжлэх ухааныг заалгаж байжээ. Улмаар Тайпины бослогыг дарахад оролцож, генералиссимус Зень Гуофаны армид захирагчийн алба хаах болсон байна. 1859 онд Фужянь мужийн цэргийн тойргийн захирагч, 1864 оноос хойш насан эцэстлээ Зүүн Хойд Хятад, Солонгос дахь эзэн хааны Бүрэн эрхт Төлөөний сайд, захирагчаар ажиллаж, Чин гүрнээс Солонгос, Япон, Хаант Орос, Өрнөдтэй байгуулсан бүх тэгш бус гэрээ, хэлэлцээрт оролцож, 1867-70 онд Хугюань-ийн дэд тэргүүн, 1871-95, 1900-01 онд Бейюань-ны Сайд, Жилийн дэд тэргүүн, 1899-1900 онд Лианьгюань-ийн дэд тэргүүний албыг хавсран ажиллаж, 1895 оны Шимоносекийн энхийн гэрээ, 1901 оны Боксёрын протоколд гарын үсэг зурсан юм. 1896 оны 6-8 дугаар

сард анх удаа Өрнө дахинаар аялж, Москва-Санкт-Петербург-Берлин-Парис-Лондон-Нью-Йорк-Филадельфи-Ванкуверт зочилж, Чин гүрэн үнэнхүү хоцрогдсныг биеэр мэдэрчээ. Оросын хаан II Николай, Германы хаан Бисмарктай уулзаж, Британий Хатан хаан Викториа түүнийг Вангийн Ялалтын төлөө Хөлөг баатарын Аугаа Их Загалмай одонгоор шагнаж байжээ.

1896 оны 6 дугаар сард Санкт-Петербургт Чин-Хаант Оросын хооронд Харилцан батлан хамгаалах гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд Москвад гүн Эспер Эсперович Ухтомскийгаас 3 сая рублийг (тэр үеийн ханшаар ойролцоогоор 1.9 сая ам. доллар байжээ Д.У) авилгалд авчээ. Э.Э.Ухтомский «Чин гүрний Стратегийн ялалтын амжилт» хэмээх дурсамж өгүүлэлдээ бичихдээ: “Харилцан батлан хамгаалах тухай гэрээ байгуулсны дараах өдөр Хаант Оросын Сангийн яамны Ерөнхийн газрын захирал Романов, Чингийн Засгийн Ерөнхий газрын дарга Люо Чжи-тай бид тэрхүү гэрээнд (мөнгө авсан баримтад Д.У) гарын үсэг зурсан юм. Түүнд Чингийн засаг баригчид Хятадын Дорнодын Төмөр замыг барьж байгуулахаар шийдвэрлэсэнээ зарлан тунхагласны төлөө 1 сая рубль, Хятадын Дорнодын Төмөр замыг барьж байгуулах хоёр талын гэрээний төлөө 1 сая рубль, Төмөр зам барьж дууссаны дараа 1 сая рубль төлбөрт өгөхөөр тохиролцсон. Баримтыг Ли Хунжанд өгөөгүй, Сангийн яамны маш нууц зэрэглэлтэй хавтас хэрэгт хадгалсан” гэжээ. Харин 3 сая рублийг Орос-Хятадын банкад хадгалуулсан байна. Сүүлд Өвлийн Ордны нууц архиваас олдсон баримтад Ли Хунжан 3 сая рублиас 1 сая 702 мянга 500 рублийг бэлнээр авсан тухай тэмдэглэл гарч ирсэн юм. Ли Хунжан алт олборлох «Монголор» хувь нийлүүлсэн синдикатыг байгуулалцсан, томоохон хувьцаа эзэмшигч байв. Боксёрын Протоколд гарын үсэг зурснаас хойш хоёр сарын дараа Бээжинд 78 насандаа нас баржээ.

Дээр дурдсан гэрээг үндэслэн ван Э.Э.Ухтомский, СПб-ийн Олон улсын худалдааны банкны тэргүүн А.Ю.Ротштейн, Ли Хунжан, Чин улсын Сангийн захирагч Сюй Цзинчень нар Москвагийн хэлэлцээрт (СПб-ийн гэрээний хавсралт) гарын үсэг зуржээ. Гэрээ ёсоор ДХТЗ-ийг 80 жилийн дараа Хятадын талд үнэ төлбөргүй шилжүүлэх, хэрэв худалдаж авах бол 36 жилийн дараа үндсэн хөрөнгө, зээл, хүү, цэвэр болон ногдол ашгийг нийтэд нь тооцохоор болсон байна. Тэдгээр гэрээ хэлэлцээнд хэлмэрчээр оролцсон хүн бол Тяньцзинд Хятадын далайн гаалийн албанд Роберт Хартын зөвлөхөөр олон жил алба хашиж, сүүлд Ли Хунжаны нарийн бичгийн дарга болсон Бельгийн харъяат Барон Виктор фонь Ю.Гроть (Bar-

on Viktor von J. Groth 1863-1931?) байв.

Грот бол Ухтомский, Коковцов нарын танил байжээ. 1895-98 онд Бээжинд Оросын ЭСЯ-нд дипломат ажилтан байсан Ю.Я.Соловьевын дурдатгалдаа бичсэнээр орос хүнтэй тун төстэй тэрбээр хятад хэл, хятад ёс заншил нэвтэрхий мэдлэгээрээ Бээжин дэх Европынхны дунд ихээхэн нэр хүндтэй байжээ. И.Я.Коростовещийн тэмдэглэлд фон Гротыг оросын харъяат, хятадын тал баримтлагч гэсэн байдаг. Тиймдээ ч Монголын тусгаар тогтнолыг таашаагаагүй тэрбээр Өргөөг орхин явсан байж болох талтай.

С. Витте, Ли нарын хэлэлцээ зөвхөн Монголд алтны уурхайн нийгэмлэг байгуулах асуудлыг шийдвэрлээд зогсоогүй энэхүү нийгэмлэгийг санхүүжүүлэх Орос-Хятадын банкыг Бээжинд нээх, аажимдаа Монголд түүний салбарыг нээх, томоохон стратегийн хөрөнгө оруулалт болох ДХТЗ-ыг барьж эхлэх асуудлыг ярилцжээ. Ингэж «Монголор»-ын асуудал шийдэгдмэгц түүнд хувь нийлүүлэн оролцох улс орнуудыг сонгох, тоног төхөөрөмж нийлүүлэх, олборлосон алтаа хаана борлуулах зэрэг ажилд шуурхайлан оржээ. «Монголор»-т Оросын алтны уурхайн нийгэмлэг «Золоторосс», Берлин дэх банкны эзэн Е. Менделсоны «Mendelssohn-Bartholdy Co.» гэдэг Германы компани, Майн дахь Франкфуртын «M.A. Rothschild & Sons», Орос дахь үйлдвэрийн асуудал эрхэлсэн Парисын банкны Ерөнхий Хороо (Societe Generale), Санкт Петербургийн олон улсын банк, Парис-Нидерландын хамтарсан банк (Banque de Paris et Pays-Bas), 1897 онд байгуулагдаж Удирдах зөвлөлд нь Ухтомский, Ротштейн, Покотилов нар ордог «Хятадын газрын баялаг ашиглах синдикат» тус тус хувь нийлүүлжээ.² «Хятадын газрын баялаг ашиглах синдикат»-ийн удирдах зөвлөлд мөн Санкт-Петербургийн Тооцоо, зээлийн банкны Ерөнхийлөгч Д.И.Петрококино, «Золоторосс»-ын Ерөнхийлөгч И.Нерпин, Олон улсын худалдааны банкны тэргүүн А.Ю. Ротштейн нар оржээ.

«Монголор» нийгэмлэгт Оросын хатан хаан Мария Феодоровна (Данийн гүнж Мария София Фредерика (1847-1928) хаан III Александрын гэргий, II Николай хааны ээж), Бельгийн хаан II Леопольд (Leopold Louis Philippe Marie Victor (1835-1909), Манж Чин улсын төрийн сайд Ли Хунжан нар хувь нийлүүлсэн байна.

«Монголор»-ын Удирдах Зөвлөлийг байгуулж, түүний бүрэлдэхүүнд 1895 оны сүүлчээр Виттегийн санаачилгаар байгуулагдан хувь нийлүүлсэн Орос-Хятадын банкны Ерөнхий хорооны дарга хунтайж, гүн Эспер Эсперович Ухтомский, «Золоторосс»-ын Ерөнхийлөгч И.Нерпин, Францын том хөрөнгөтөн

банкир А.Ротшильд (Alphonse James de Rothschild (1827-1905), түүний хүргэн С-Петербургийн Олон улсын худалдааны банкны тэргүүн А.Ю. Ротштейн (Adolf Julevich Rothstein), түүний орлогч Л.Ф.Давыдов, Удирдах Зөвлөлийн гишүүн Н.И.Филипьев, Бельгийн санхүү-үйлдвэрийн төлөөлөгч Браун де Тьеж (Alexandre de Browne de Tiege (1841-1910), С-Петербургийн Тооцоо ба Зээлийн банкны Удирдах Зөвлөлийн дарга Д.И.Петрококино нар орж, А.Ю. Ротштейныг «Монголор»-ын Ерөнхий захирал, Ухтомскийн саналаар бельгийн харьяат Барон Виктор фон Ю.Гротыг «Монголор»-ын Өргөөгийн салбарын захирлаар 4 жилийн хугацаатай тус тус томилжээ. «АО Монголор»-ийн төв байр нь Санкт-Петербуркт, санхүүгийн жил 10 дугаар сарын 1-нээс, дараа жилийн 10 дугаар сарын 1-нд, тайлангаа орос, франц хоёр хэлээр зэрэг гаргаж байжээ.³

1902 онд Орос-Хятадын банкны санхүүжилтээр нийслэл өргөөд тус банкны салбарын удирдлага байрлах барилгыг Гротын урьж авчирсан голланд уран барилгачны төслөөр чулуугаар хоёр давхар барьж 1905 оны 8 дугаар сард ашиглалтанд оруулсан нь нийслэл Хүрээнд баригдсан анхны европ маягийн загвар бүхий сүрлэг байшин болж сүндэрлэсэн байна. Энэ барилгад «Монголор»-ын удирдлага ч зэрэг оржээ. Тухайн үед хүрээнийхэн сайхь барилгыг «Монголор» алтны уурхайн эрхэлсэн түшмэл барон фон Гротын нэрээр «Гротын улаан» гэж нэрлэх болжээ. Ням гараг бүрт энд үнэн алдартны сүмийн цуглаан болдог байсныг Москвагийн шинжилгээний ангийхэн тэмдэглэсэн байдаг.

1903 оноос С.Виттег залгамжлан Сангийн сайд болж, Ерөнхий сайд И.Л.Горемыкин, П.А.Столыпины үед үргэлжлүүлэн, 1911-14 онд Ерөнхий сайдаар ажилласан гүн Владимир Николаевич Коковцев (1853-1943) бол Монгол дахь Оросын ашиг сонирхлыг тууштай дэмжигч байв. Монгол дахь Хаант Оросын цорын ганц томоохон үйлдвэр «Монголор»-т санхүүгийн дэмжлэг нэн шаардлагатай байсан 1904-05 оны хүнд үед Коковцев эдийн засгийн төдийгүй улс төрийн ихээхэн хүч чармайлт гарган байж түүнийг өөд нь гаргаж ирж байсан ажээ.

«Монголор»-ын үйл ажиллагааны зарчим нь концессийн тодорхой бичил ордуудыг алт угаагчдад гэрээгээр түрээслүүлэх явдал байв. «Монголор»-т И.В.Покровский, В.Г.Сонгайлло, Л.И.Домровский, Е.Е.Зеленков, Б.Г.Ольшамовский, Л.Ф.Грауман зэрэг туршлагатай уул уурхайн инженерүүд уригдан ирж ажиллаж байжээ. Покровский Гротын дараа Уурхай хариуцсан Ерөнхий

даамал болсон байна.

Портсмутын гэрээний дараа 1906 оны 8 дугаар сарын 9-нд «Монголор» хувьцаат нийгэмлэг «Манжуурын уул уурхайн үйлдвэрийн Нөхөрлөл»-тэй гэрээ байгуулснаар тус байгууллагын Зүүн Хойд Хятадад алт, мөнгө, платинум, зэс, нүүрс олборлох концессийн эрхийг өөртөө шилжүүлж, үл хөдлөх бүх хөрөнгийг худалдан авсан байна. Л.Ф.Давыдов, А.И.Путилов, А.Ю.Ротштейн нар Чин улсын засаг баригчдаас концессийн эрх авч энэ Нөхөрлөлийг 1902 оны 6 дугаар сард Харбинд байгуулжээ.

«Монголор»-ын ажиллагаатай холбоотой Оросын алтны уурхайн нийгэмлэг «Золоторосс» нь 1895 онд 5 сая рублийн капиталтайгаар байгуулагджээ. Түүний 60 хувийг Францын тал эзэмшиж байв. Үүнтэй нэгэн зэрэг Петербурgt 6 сая рублийн үндсэн хөрөнгө бүхий Орос-Хятадын банк байгуулагджээ. Энэ банкны үндсэн хөрөнгийн 5/8 хувь нь Парисын банканд, 3/8 нь Германы банктай холбоо бүхий Петербургийн банкуудад хамаарагдах болсон бөгөөд удалгүй тэд Шаньхай, Бээжин, Хонгконг, Тяньжин, Харбин, Хүрээ, Улиастайд өөрийн салбараа нээсэн юм. Энэ банк “мексик доллар”, “купин тээл”-ийн мөнгөнд эвсгэртүүдийг гүйлгээнд гаргасан нь Алс Дорнодын олон улсын худалдаанд нэр хүндтэй валют болсон юм. Орос-Хятадын банк 1910 оноос Орос-Азийн банк болон өргөжиж Монголд ч салбараа нээсэн байна. Орос-Хятадын банк Хүрээнд салбараа нээсэн нь «Монголор»-ын үйл ажиллагаатай шууд холбоотой байсан байх агаад банкны Монголын салбарын захирал Н.Ф.Степанов өөрөө мөн хувьцаа эзэмшигч байв.⁴

«Монголор»-ын 1900-12 онуудад тараасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн заримаас дурьдвал Браун де Тьеж 1900 онд 1520 ширхэг, 1901 онд 5320 ширхэг, 1911 онд 750 ширхэг хувьцаа авчээ. 1900-06 онд бельгичүүд 1 сая рублийн хувьцаа, 1912-15 онд Орос-Хятадын банк 10 мянган хувьцаа, Санкт-Петербургийн олон улсын банк 2000-3500 хувьцаа, «Золоторосс» 5000 хувьцаа, Фон Грот 1900 онд 1632, 1903 онд 1114 ширхэг хувьцаа авчээ. Ухтомский 1903 онд 1650, 1906 онд 1434 ширхэг авсан байна. Энэхүү жагсаалтанд Ротштейн, Давыдов, Бээжинд элчин сайд байсан, Орос-Хятадын банкны Бээжингийн салбарын захирал Д. Д.Покотилов, Орос-Хятадын банкны Удирдах зөвлөлийн гишүүн А.И. Путилов, Хятадын төв банкны Дэд Ерөнхийлөгч Чжан Цзяо зэрэг нийтдээ 100 гаруй хүн, пүүс, байгууллагуудын нэр байх бөгөөд хувьцааны нийт тоо нь 1900 онд 7878, 1911 онд 779, 1912 онд 10 мянга хол давсан байна.⁵

**«Монголор»-ын үйл ажиллагаа ба Олноо өргөгдсөн
Богд хаант Монгол Улс**

Хөгжлөөр буурай байсан Монгол оронд олон улсын хүчирхэг капиталын хөрөнгө оруулсан алтны энэ нийгэмлэг онцгой эрхтэй байв. Тухайлбал, өөрийн цагдаа, шүүхтэй, утсан болон зам харилцаатай, гэрэл цахилгаантай, засварын газартай, тухайн үедээ орчин үеийн гэж хэлж болохуйц дэд бүтэцтэй, Америкт үйлдвэрлэсэн уурын болон усан тээрэмтэй, олон арван фордын машин техниктэй, хамгийн их нь 10 мянга гаруй ажилчидтай (1910-12 онд Д.У) жижигхэн вант улс байжээ. «Монголор» нь Монголд төдийгүй Орост ч капиталист томоохон аж ахуйн нэгжид тооцогдож байв.

Оросын элчин И.Я.Коростовец өдрийн тэмдэглэлдээ бичихдээ: Монголорын зарим түшмэд шуналтай гэмээр ихээхэн баяжих сонирхолтой, нэлээд хэмжээний мөнгөтэй болсон, тэр хэмжээгээр Оросын консулын газар, Монголын Засгийн газарт нөлөөлөх санаархалтай, үүнд нь Ерөнхий сайд Намнансүрэн, да лам Цэрэнчимэд нар ихэд эгдүүцдэг байсныг тэмдэглэсэн байдаг.⁶

Оросын эрдэмтэн Е.М. Даревскаягийн бичсэнээр Ерөө голоор жижиг оврын усан онгоц явж байсныг тэмдэглэсэн байна. Москвагийн худалдааны шинжилгээний ангийн тайланд тэмдэглэсэнээр: “4 дүгээр сараас 10 дугаар сар хүртэл Ерөө голоор «Серафим», «Работник» гатаглаг онгоц нь Америкийн Миссури мөрөнд явж байсан ба Сибирээс оруулж ирсэн. Уг нь түүнийг Өргөө хүртэл явуулах санаатай байсан...” гэжээ. Эдгээр онгоцууд урьд нь “Байгаль нуурын усан онгоцны болон худалдааны нөхөрлөл хэмээх компанийх байсан” гэжээ.⁷

«Монголор» алтны уурхайн эзэд алтны ашиг орлогоос гадна аж ахуйн өөр салбарт ашиг нээхийг эрмэлзэж байжээ. 1916 оныг 10 дугаар сард Монголын ГЯЯ-ны Умард хэлтэст Уурхайн хэргийг ерөнхийлөн шийтгэх түшмэл барон Фиттингхоффоос мэдүүлсэн бичигт: «Хараа голын эрэг дээр хоёр десятин газар хэмжээлэн олгож, Хятад ба бусад тариачны тариаг тээрэмдэх усны халуун уурын хүчээр хөдлөх тээрэм нэгийг барихыг зөвшөөрөх ажаамуу. Миний байгуулсан тээрмийн орчин тойронд нэгэн зуун модны дотор бусад ямарваа хүн хар тээрэм тавих эрхийг олгож үл болгоох ажаамуу» гэжээ.⁸ Түүнд ГЯЯ зөвшөөрсөн хариу өгөхдөө бусдад тээрэм тавиулахгүй байх гортигийг 20-30 модноос хэтрүүлэхгүй болгон тогтоосон байна.

Богд гэгээний Засгийн газар байгуулагдсаны дараа 1912 оны 6 дугаар сарын 22-нд “Монголор”-той (“Монголор”-ыг

төлөөлж Оросын консул гэрээнд гарын үсэг зуржээ) 22 зүйл бүхий гэрээ байгуулж, 1931 он хүртэл 19 жилийн хугацаатай концесс шинээр олгохдоо аанай л дурдсан хоёр аймгийг л хамруулжээ. Гэрээний 4 дүгээр зүйлд тус алтны уурхайн нийгэмлэг олборлосон алтны 16.5 хувь хагасыг биет алт, тухайн ханшаар Оросын рубль эсвэл мексик доллараар Богд гэгээний санд татвар хэлбэрээр оруулж байхаар заажээ. Түүнчлэн «Монголор»-ын олон уурхайд тусгай монгол түшмэдийг тавих, хянах, алтны ордыг хулгайлах, завших явдалтай тэмцэх үүрэг өгчээ.⁹ Түүнчлэн «Монголор» нь Богдын Засгийн газрын Хаант Оросоос олгох зээлийн хөрөнгөний гол баталгаа, барьцаа болж байв.

Олноо өргөгдсөн 3 дугаар он, өвлийн дунд сарын шинийн 1-нд Богд гэгээний Засгийн газар “Монгол улсын хязгаар доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм, хэмжээ” хэмээх 25 зүйлийг батлан явуулжээ. 1 дүгээр зүйлд «Тус улсын ба Орос, Мэй улсын бусад аль ч улсын хүмүүн болбоос Дотоод яамнаа тодорхой мэдүүлэх, гадаад улсын хүмүүн болбоос Гадаад яамнаа мэдүүлэн дүрмийн ёсоор хэлэлцэн тэмдэгт бичиг хүлээн авбаас зохимой...» гэжээ. Мөнхүү дүрмийн 25 дугаар зүйлд заахдаа: «... уурхайн хөрөнгөөс хувь бодож манай улсын санд тушааваас зохино. Алтны 100 хувиас 20-30 хувь, мөнгө ба мөнгөн ус, хорголжны 100 хувиас 15-25 хувь, чулуун нүүрсний тос ба гууль, зэс, тугалгын 100 хувиас 10-12 хувь, чулуун нүүрс ба төмрийн 100 хувиас 5-15 хувь, цагаан алт ба очир алмаз чулууны 100 хувиас 40-50 хувь, усан болор ба олон зүйлийн эрдэнийн чулуунаас 100 хувиас 30-40 хувьд хүргүүлэхээс хэтрүүлэхгүй болгон уурхайн хөрөнгийг элбэг, ховор ба үйлдвэрийн хүнд, хөнгөнийг нарийвчилан хянаж тухайд нийлүүлэх гэрээ бичгийн дотор хэлэлцэн тогтвоос зохимой» гэжээ.¹⁰

ОХУ-ын Түүхийн архивт хадгалагдаж буй «АО Монголор»-ын баримтад 1912 оны гэрээний дагуу Хутугтын нэр дээр Орос-Азийн банкны Шаньхайн салбарт мөн орлогын (ногдол ашгийн биш Д.У) данс нээсэн байна.¹¹

Богд хаан 1919 онд Франс А.Ларсон лугаа хамт Шаньхай явж «Орос-Азийн банк» дахь өөрийн сангийн данс дээр хуримтлагдаж хадгалагдсан (400 кг алт ?) үнэнт зүйлсээ баталгаажуулсан байдаг. ТЕГ-ын архивт буй баримтаар 1930-аад оны дундуур Монгол Улсын Засгийн газар Шаньхайн банк дахь алт, бусад үнэт зүйлсийг өөрийн мэдэлд шилжүүлэн авсан байдаг.¹² БНМАУ эх орны дайны жилүүдэд 1942 оны 2 дугаар сард ЗХУ-ын Внешторгбанканд 2.5 сая

төгрөг, 100 мянган ам. доллар, 3.8 сая рублийн өртөг бүхий 300 кг алт шилжүүлж, түүгээр Т-34 танк 32, Т-70 танк 21 ширхэг бүгд 53 танкаас бүрдсэн «Хувьсгалт Монгол» хэмээх бригадыг байгуулж, 1943 оны 1 дүгээр сарын 12-нд Улаан армийн улаан тугийн одонт танкийн 112 дугаар бригадад гардуулсан билээ. Тэрхүү алтны дийлэнх хэсэг нь «Монголор»-ынх байсан болов уу.

«Монголор»-ын томоохон түрээслэгч байсан К. В.Титовын 1927 онд бичсэнээр Монголын санд мөн алт хайх, олборлох газар авах, хэрэглэсэн мод, цэргийн хураамж нэмж авдаг байжээ. Фон Грот санд алт чигээр нь биш, харин ямар нэгэн гадаадын чамин сав суулга, бэлэг дурсгал өгөх төдийгөөр татвараа хаадаг байжээ.¹³ Тухайн үед хүндхэн байдалд ороод байсан уг концесс жинхэнэ ёсоор хэрэгжиж чадахгүй байсан гол учир нь дэд бүтэцгүй байснаас зарим зүтгэлтнүүдийн адил фон Грот нийслэл Хүрээгээр дайруулан Дээд Үд, Бээжинг холбосон төмөр зам тавихыг чармайж байсан ажээ.

Мөн тэрбээр уул уурхайн ажил төдий л сайн мэдэхгүй байсан учир Америкийн Калифорнийн алтны уурхайд багагүй хугацаагаар ажиллаж байгаад 1912 онд Монголд эгэн ирж, Богд гэгээний Засгийн газраас уурхайн зөвшөөрөл хүсч байсан боловч үүнийг нь татгалзжээ. «Монголор»-т Америкаас оруулж ирж байсан тоног төхөөрөмж нь Монгол орны нөхцөлд төдийлөн зохицдоггүй байсан тухай эх сурвалжид тэмдэглэсэн байдаг.

Америкаас 40 гаруй инженер-техникийн ажилчид ирсний нилээд нь хожим нь газар түрээслэн авчээ.¹⁴ 1901 онд Сэцэн хан аймгийн Хэрлэн Барсын Чуулган даргад Хүрээний амбанаас илгээсэн бичигт Монгол дахь алтны уурхайн хэрэгцээнд зориулан Америкаас худалдан авчирсан машин хэрэгсэл, мөн тэндээс уригдсан 46 инженерийн хамт Жанчхүүд (Хаалган Д.У) ирээд байгааг мэдэгдэж байжээ. 1899 онд хожим АНУ-ын Ерөнхийлөгч болсон Х.Хувер тэргүүтэй алт хайгчид ч Өргөөд ирж байсан ажгуу.

«Монголор» нийгэмлэг 4 жилд нэг тонноос дээш, үүний дотор 1910 онд 1974,4кг [2 сая 501 мянга 691 рубль буюу 120 пүү алт] олборлож байсан нь Монгол Улсын түүхэнд 1990 оны байдлаар олборлосон хамгийн их алт болж байна.¹⁵ Олборлосон алтны нилээд хэсэг нь Тяньжинээр Америкт, багагүй хэсэг нь Оросоор дамжин Берлин, Амстердам, Парист гарч байжээ. 1912 он гэхэд 1 сая 154 мянга 222 рублийн үнэ бүхий алт дээрх сувгаар гарчээ.¹⁶

«Монголор» нийгэмлэг 1902-19 онуудад 606 пүү алт олборлосны дотор зөвхөн Ерөө голын сав газруудаас 460 пүүг

олборлож байжээ. Мөн ч 300 орчим пүү алтыг нууцаар ихэнхдээ Хятад руу хил давуулж байсан тухай тэмдэглэл үлдсэн байна. Тиймээс энэ хугацаанд нийт алт олборлолт 10 тн-оос хол давж байжээ. Архивийн баримтаар Хэнтийн Толгойт, Буурал, Могой, Их Харгана зэрэг ордод 1907, 1912 онуудад алт олборлолт эрчимтэй явагдаж, жилд 2 тн хүрч байжээ. «Монголор»-оос гадна тэдний эзэмшлийн талбайд хувийн гар аргаар алт олборлогчдоос худалдан авсан алт 71 пүү хүрч байсан тухай тоо бүртгэлийн данс архивт байна.¹⁷ Иймээс эх сурвалжаас үзэхэд дурьдсан хугацаанд «Монголор» нийгэмлэг нь 900 пүү буюу ойролцоогоор 14670 кг алт олборлосон гэсэн дүн гарч байгаа юм.

Хятадын Номхон далайн харилцааны институтээс 1931 оны 10-11 дүгээр сард Ханчжоуд зохион байгуулсан “Хятадын уул уурхайн үйлдвэр дэх гадаадын хөрөнгө оруулалт” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд судлаач Сие (С.У.Hsieh) болон Чжу (М.С.Chu) нарын тавьсан илтгэлд тэмдэглэснээр «Монголор» 1911 онд хамгийн өндөр буюу 59.600 унц (1 ounce=28.34 grams Д.У) алт олборлосон, 1915 онд Зуун-Мод (одоогийн төв аймгийн нутаг) хэмээх газарт хайгуулаар шинээр алт илрүүлж, 1915-16 онд 5 мянган унц алт, 1910-19 онд нийт олборлосон алт 319.347.687 унц буюу 5.770.333 ам. доллар болсон. Алтны агууламжаас хамаарч ажлын хөлс 1 метр шоо дөрвөлжин газар (cubic yard), 2-3 тохой (ft.=30.48cm Д.У) тутамд дунджаар 22 сент, өндөр агууламжтай газарт 30-35 сент, харин алтны сорьц (ratio of carat буюу алтны орц) 862-974, олборлолт, угаалтын зардлаа хасаад 3-5 дахин илүү ашиг олж байсан гэжээ.¹⁸

«Монголор» алтны уурхайд хятад, орос, монгол (зарим эх сурвалжид мөн хятадын солонгосчууд ажиллаж байжээ Д.У.) зэрэг олон тооны ажилчид ажиллаж байсан ажээ. «Монголор»-ын зөвхөн нэг салбар Их хараатын алтны уурхайд 1912 оны дундуур Орос, Хятад бүгд 800 шахам хүн ажил хийж байгаа ба эдүгээ дахин үйлдвэрийн хуаз хүн 700 орчмыг нэмэн авахаар зэхэж байна гэж тус уурхайн Монгол түшмэл Гонгор Сангийн яамандаа мэдээлж байжээ.¹⁹ Ер нь Богд Хаант улсын үед «Монголор»-ын харьяа алтны 22 уурхайгаас ажилтай байсан 15 уурхайд дундажаар 2500 гаруй, үүнээс 250 орчим Орос ажилчид хөдөлмөрлөж байв. Судлаач Даревская 1909-10 онд «Монголор»-т ажиллагсдын тоо дээд хэмжээндээ буюу 9-10 мянгад хүрч, Октябрийн хувьсгалын дараа 1921 онд 2600 болтлоо буурсан гэж бичжээ.

Элчин В.Рокхилл 1913 оны 12 дугаар сард нийслэл Хүрээгээр

дайран өнгөрсний дараа жилийн 5 дугаар сард нийтлүүлсэн «The Question of Outer Mongolia» өгүүлэлдээ: Оросын хяналттай «Монголор уурхай» роялтын татварт олборлосон алтны 16.5 хувийг Богд хааны санд оруулдаг агаад 1912 онд оросоор 72 пүү, англиар 2.592 фунт (1.2 тн Д.У), 1913 онд огцом унаж, 46 пүү буюу 1.650 фунт (760 кг Д.У) алт олборлосон, «Монголорт» зуны улиралд 3 мянга орчим хятад иргэд, 2-3 мянган орос иргэд, орос, америк нийлээд 60 гаруй инженер-техникийн мэргэжилтнүүд ажилладаг болохыг тэмдэглэсний гадна «Монголор»-ыг Орос-Америкийн хамтарсан уурхай гэсэн байдаг.²⁰ Тэрбээр Америкийн «Peking Mongolor Co»-тай андуурсан бололтой. Харин Монгол ажилчдын тоо дөнгөж 70 орчимд хүрч, тэд гол төлөв манаач, цагдаа, тэрэгч зэрэг хөлсний ажил хийж байжээ. Монгол ажилчдын тоо ийм цөөн байсан нь шашин шүтлэг, зан үйлтэй холбоотой байсан байж болох талтай.

Дээр дурдсан хятад хоёр судлаачийн илтгэлд мөнтэмдэглэснээр урьд жил нь Орос, Хятад, Монголд болж байсан улс төрийн үйл явдлаас шалтгаалан тус нийгэмлэг 1919 онд үйл ажиллагаагаа бараг зогсоогоод байсан ажээ. Харин 1920 оны хавар Өргөөд Америкийн «The Mongolian Trading Company» «Монголор»-ын орос даамалтай гэрээ байгуулж 30[?] жил үйл ажиллагаа явуулах концессын эрхийг нь шилжүүлэн авч, үүнийг нь Хятадын Засгийн газар баталгаажуулжээ.²¹ Гэвч удалгүй мөн оны зун АНУ-ын өөр нэг үйлдвэр, худалдааны «Peking-Mongolor Co.» пүүсийн эзэд Бээжинд хувь нийлүүлсэн «Монголор»-ын Ерөнхий даамал, инженер барон А.К.Фиттингхофтой (A.K.Fittinghoff) концессын эрх, үл хөдлөх нийт хөрөнгийг 600 мянган ам. доллараар шилжүүлэн авах хэлэлцээ хийжээ.²²

1920 оны 4 дүгээр сард нийслэл Өргөөд танилцах зорилготой нууц томилолтоор ирж, Монголын нөлөө бүхий ноёдтой уулзсан Хятад дахь АНУ-ын консул Ч.Эберхардттай мөн Хүрээн дэх «Mongolian Trading Company»-н төлөөлөгч А.М.Гуптилл уулзаж, өөрийн санал, байр сууриа албан захидлын хэлбэрээр бичиж консул Эберхардтад гардуулж байжээ. Гуптилл бичихдээ: Монголд Америкийн хоёр компани Өргөөд шууд үйл ажиллагаа явуулж буй. «China American Trading Co.» болон «China Java Expot Co.» Хаалганаас ажлаа явуулдаг, бид саяхан Хиагтад салбараа нээсэн, удахгүй Алтай хотод нээнэ, Монгол дахь Америкийн худалдаа жил болгон хоёр сая ам. доллараар өсч байна. Монголын үл мэдэгдэх газар нутагт Америкийн уул уурхайн синдикатууд үйл ажиллагаа

явуулах өргөн боломж байна. «Монголор» уурхайн компанийн суурин захирал Барон Фиттингхофф (Resident Director Baron Fittinghoff) үйл ажиллагаа явуулж буй боловч ямар ч дэмжлэг туслалцаа байхгүй байгаа, большевикийн нөлөө орж ирж буй, хятадуудын хүнд суртал, тиймээс Америкийн «Int'l Banking Corporation»-ын салбарыг Өргөөд нээх, Өргөөд АНУ-ын Консулын газрыг нээхийн чухлыг дурдсан байв. Эдгээр хүсэлтүүд үнэхээр бодит байдалтай нийцэж байсан бөгөөд Ч.Эберхардт Бээжин буцаж, Монголын талын бичиг, захидлыг Вашингтонд яаралтай хүргүүлсэн ажгуу.

Төгсгөл

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын дараахан Хаалган хотноо Гадаад Монголыг тухайлан хариуцсан АНУ-ын анхны суурин консул Самуэл Сокобин нийслэл Өргөөд анхны томилолтоор ажилласныхаа дараа 1921 оны намар Вашингтонд илгээсэн нууц тайландаа: Москвад Монгол-Зөвлөлтийн хооронд бие биеэ харилцан хүлээн зөвшөөрөх тухайд нууц хэлэлцээ явагдаж байгааг тэмдэглээд, энэ үеэр большевикууд Гадаад Монгол дахь хуучин оросын бүх өмч, хөрөнгийг өөрийн мэдэлд авах асуудал тавигдаж байгаа бололтой, тиймд «Монголор»-ыг өөрийн улсын «Peking Mongolor Co.»-т лизингээр худалдан авахын чухлыг анхааруулж байжээ.²³ Сокобин өөрөө «Peking Mongolor Co»-ийн нэрийн өмнөөс Сангийн яамтай Монголд алт олборлох лизингийн шинэ хэлэлцээ эхлүүлж, [С.] Данзан үүнд нь ач холбогдол өгч байсан боловч орос зөвлөх Бутин саад учруулж байжээ. Тиймээс Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч [Б.] Цэрэндоржийн дэмжлэгт найдаж байсан сонирхолтой баримтыг Алиса Кэмпи зохиолдоо бичсэн байна.²⁴

Ардын хувьсгал ялсны дараа Монгол Улсын Ардын Засгийн газрын ГХЯ-ны тэргүүн сайд Б.Цэрэндоржоос АДБНУ-ын ГХЯ-ны тэргүүн сайдад 1922 оны 4 дүгээр сарын 12-нд явуулсан бичигтээ: «Монголор» нийгэмлэгийн хөрөнгө хогшлийг Монгол улсын хөрөнгө болгох тухай Ардын Засгийн газрын «Ухуулан тушаах бичиг» хэмээх 8 зүйлт шийдвэрийг хүргүүлжээ. Уг шийдвэрийн зарим заалтыг сийрүүлбэл:

«Нэгдүгээр зүйл: *Нэгэн мянга есөн зуун хорин нэгдүгээр оны Европын хоёр сарын шинийн нэгэн хүртэл “Монгол-ор”-ын хорооны Монгол газар байсан бугд хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө, хогшлыг Монгол улсын хөрөнгө болгов.*

Хоёрдугаар зүйл: *Нэгэн мянга есөн зуун хорин нэгдүгээр оны Европын хоёр сарын шинийн нэгнээс хойш хэн нэг хүн “Монгол-*

ор”-ын хорооны ямар юмыг хэнээс яахин авч, эдүгээ эзэлж бүхнийг Монгол Ардын Засгийн Газраа эгуулэн тушаамой.

Гуравдугаар зүйл: Авсан юмыг энэ арван хоёрдугаар оны Европын есөн сарын шинийн нэгний дотор Монгол Улсын Засгийн Газрын төлөөлөл дор тушааж уг авсан газар буюу уг газар хургэх аргагүй болбоос Зуунмод, Ерөө, Могой, Хүдэр зэргүүдийн аль нэгэн дор хургэж өгмөй. Юмыг эдүгээ эзэлж буй хүний хүчээр хургуулмой.

Дөрөвдүгээр зүйл: “Монгол-ор”-ын хороо анхны хөрөнгөө авсан зүйлийг бүрэн бүтэн тушааж, авч буй хүнээс гарын тодорхой тэмдэг авмой. Хэрэв хөрөнгө эзэмшигчээс юмыг гэмтээж эвдсэн зүйл байвал тэр хүнээр засуулах буюу засварын хөлсийг авмой.

Наймдугаар зүйл: Европын есөн сарын нэгний дотор ул тушаах аваас хөрөнгийг хулгайлан авч, даран далдалснаар үзэж даруй барьж, байлдааны цагийн хуулиар чангалан шийтгэж, улсын хөрөнгө хогшлыг хурааж авмой»²⁵ гэжээ.

ОХУ-ын түүхийн архивийн сан хөмрөгт буй баримт сэлтээр бол Зөвлөлт Засгийн газар 1918 оны 7 дугаар сарын 20-нд гадаад үйл ажиллагаа явуулж байсан Хаант Оросын бүх хувьцаат нийгэмлэгүүдийг улсын болгох тухай Хууль гаргасны дагуу «АО Монголор-1900-1919», түүний гол санхүүжүүлэгч «Орос-Хятадын банк-1895-1926» нийгэмчлэгдэж, үйл ажиллагаатай нь холбоотой бүх гол баримт бичгүүдийг 1927 онд улсын архивт шилжүүлсэн байна.²⁶

ОХУ-ын архивын шинэ баримтад «Монголор»-ын үйл ажиллагаанд ЗХУ хэрхэн оролцох талаарх ГЯЯ-ны асуулгад БХК/б/Н-ын ТХ-ны УТТ-ны 1925 оны 2 дугаар сарын 5-ны хуралдаанаар И. Сталин шийдэхдээ: **ЗХУ өргөн хүрээтэй оролцох, түүнд хяналт тавих, Америкийн оролцоог хязгаарлахаар тогтсон боловч бдугаар сарын 11-ны хуралдааны бдугаар протоколд И.Сталины шийдвэрээр «Монгол-ор»-ын үйл ажиллагаанд ЗХУ оролцох шаардлагагүй гэж үзэж, харин Монголын Засгийн газарт Германы капиталыг татан оролцуулах санал тавьж, тийнхүү оролцуулахад ЗХУ хүчин туслахад бэлэн»** байгааг мэдэгдсэн нь тун сонирхол татаж байна.²⁷

1922-27 он хүртэл Монгол Улсаас Өрнөдийн орнуудтай эдийн засгийн гадаад харилцааг үүсгэн хөгжүүлэх хэрэгт ЗХУ анхандаа нааштай хандаж байсныг эл баримт харуулна. Нөгөө талд 1920-иод оны эхэн гэхэд ЗХУ янз бүрийн үйл ажиллагаагаар өөрийн

нэр хүндийг олон улсын тавцанд ямар ч байсан мэдэгдэхүйц өсгөж чадсан бөгөөд Герман, Англи, Итали, Австри, Дани, Норвеги, Швед, Финлянд, Франц, Грек, Турк улсууд дараалан тус орныг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосон юм. Тиймээс ЗХУ Өрнөдийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаагаа идэвхтэй өргөжүүлэн хөгжүүлж эхлээд байсан үе байв.

XIX зууны сүүлчээр Умард Америк, Австрали, Өмнөд Африкт алтны томоохон орд газрууд нээгдэж, энэхүү дуулианаар Европ, Азийнхан тэр зүгт аз туршихаар хошуурч байх зуур Монгол газар алтны орд нээгдсэн тухай мэдээ ч түүнээс дутуугүй түгж байсан байх бөгөөд Өвөр Байгалиас Оросууд, Хойд Хятадаас нутгийн иргэд Түшээт хан, Сэцэн ханы нутагт олноороо ирж ажиллаж байв. Олон улсын хөрөнгө оруулалттай «Монголор» хувьцаат нийгэмлэг нь хэдийгээр 20 илүү жил үйл ажиллагаа явуулсан боловч Монгол Улсын сан хөмрөгийг аривжуулах, Монгол газар уул уурхайн үйлдвэрлэлийн эх суурийг тавих үйлст зохих нөлөө үзүүлсэн гэж дүгнэж болохоор байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ Федеральное Государственное учреждение Российский государственный исторический архив. РГИА. Акционерное Общество Рудного дела Тушетухановского и Цеценхановского Аймаков в Монголии “(Монголор)” 1900-1919 гг. Ф.72. опись 1

² РГИА. Ф.72. опись 2-4

³ РГИА. Ф.72. опись 1. Д.1 Устав об образовании «АО Монголор»

⁴ РГИА. Ф-1352. Опись 1. Д.14. «АО Русско-Китайский банк 1895-1926 гг.»

⁵ РГИА. Ф.72. опись 3. Д.13 АО (протокол, доклад Правления, список акционеров, отчет, протоколы и Заключение Ревизионной комиссии) русский и французский язык

⁶ Коростовец И.Я. Девять месяцев в Монголии. Дневник уполномоченного в Монголии Август 1912-Май 1913 г. УБ., 2009, с. 285

⁷ Е.М.Даревская. Русская промышленность и наёмный труд в дореволюционной Монголии. Труды Иркутского университета. Серия историческая, вып. 4, Т. 31, 1963, с.49

⁸ УТТА. Автономитын фонд. А-6. Т. 566 ХН. 20

⁹ УТТА. Автономитын фонд. А-6. Т.566 ХН. 20

¹⁰ Мөн тэнд

- ¹¹ РГИА. Ф.23. опись 1. Д.133 АО (протокол , доклад Правления, список акционеров, отчет, протоколы и Заключение Ревизионной комиссии) русский и французский язык
- ¹² ТЕГ-ын Тусгай архив. Ф.3
- ¹³ Газ: «Известия Улан-батор хото», 1927.1.22
- ¹⁴ УТТА. Автономитын фонд. А-6. Т. 577 ХН. 16
- ¹⁵ «Ардын эрх» сонин, 1995. 2. 4. № 20
- ¹⁶ УТТА. Автономитын фонд. А-6. Т.538 ХН. 22, жур: “Китай и Япония” 1916. № 241
- ¹⁷ АО Рудного дела Тушетухановского и Цеценхановского Аймаков в Монголии “(Монголор)” 1900-1919 гг. Ф.72. опись 4-5
- ¹⁸ Hsieh C.Y.,Chu M.C. «The Von Grotte, Gold Concession in Outer Mongolia»-Foreign Interest in the Mining Industry in China. China Institute of Pacific Relations. Shanghai, China, 1931, pp. 40-46
- ¹⁹ УННС. Чэнь Цзун-Цзо. Гадаад Монголын ойрхи үеийн түүх. Шаньхай., 1922. (орч. Г.Бадрах-Баатар), 88 дахь тал
- ²⁰ Rockhill W.W. «The Question of Outer Mongolia»- Journal of the American Asiatic Association XIV(4), May,1914, pp. 102-109
- ²¹ Hsieh C.Y.,Chu M.C. «The Von Grotte, Gold Concession in Outer Mongolia»-Foreign Interest in the Mining Industry in China. China Institute of Pacific Relations. Shanghai, China, 1931, pp. 40-46
- ²² РГИА. Ф.23. опись 1. Д.133 АО
- ²³ Alicia Campi... The Impact of China & Russia on US-Mongolian Political Relations in the Twentieth Century. N.Y.:2009 p. 145
- ²⁴ Ibid. p. 149
- ²⁵ УТТА. Автономитын фонд. А-6 Т.125 ХН. 10
- ²⁶ РГИА. АО Рудного дела Тушетухановского и Цеценхановского Аймаков в Монголии “(Монголор)” 1900-1919 гг. Ф.72. опись 1
- ²⁷ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичгүүдэд. I боть. (1920-1932 он), УБ., 2005, 179 дэх тал